



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Агаарын навигацийн нислэгийн удирдагч, Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албаны байцаагчдын эрүүл мэндийн даатгал /220 ажилтан/" -ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Б.Батбулган  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн  
хөдөлгөөний үйлчилгээний албаны дарга)

Гишүүд:

Б.Батмагнай  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэхийн  
эрүүл мэнд, сэргээн засах албаны Эрүүл мэнд,  
спорт сургалтын тасгийн их эмч)

А.Энхцэцэг  
(“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл” Төрийн бус  
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Ц.Дарханбат  
(“Тактижент” Төрийн бус байгууллагын тэргүүн  
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Э.Энхжин

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Б.Батбулган)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжин)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА